

11

ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

С.Эрдэнэбилэг

Тулгамдсан зүйл. Үндэсний эдийн засгийн шинэтгэл эрчимжиж буй үед гадаадын зээл тусламжийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөг судлаж, удирдлага, мониторинг, мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирсэн. Улсын секторын тайлангийн чухал бүрдэл хөгжлийн албан ёсны тусламжийн мэдээллийг олон улсын жишгийн дагуу шинэчлэх нь зайлшгүй болсон. Ялангуяа гадаадын зээл тусламжийн удирдлагын тогтолцоог хөгжүүлж, санхүүгийн хэмжилтүүд хийгээд өгөгдлийн сангуудын хувиргалт, өрийн үйлчилгээ, тусламж ийн орлого, бусад сангуудийн жолоодлогын параметруудийг сайжруулах явдал шаардагдаж байна.

Монгол улсын үндэсний тооцооны системийг дэмжих гадаадын зээл, өрийн үйлчилгээ, тусламжийн орлогын индикаторууд ба параметруудийн гаргалгаа, өгөгдлийн сангийн хувиргалт ба хэмжил зүй, санхүүгийн тайлагналын хэв загварыг хөндсөн судалгааны бүтээлүүд илт үгүйлэгдэж байгаа билээ.

Судалгааны зорилго. Хөгжлийн албан ёсны тусламжийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, гадаад зээлийн багц, тусламжийн орлогын мэдээллийг үндэсний хүрээнд загварчилж, жолоодлогын параметруудийг төгсжүүлэхэд чиглэсэн. Дээрхи зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Гадаадын зээл тусламжийн сэтгэлгээний чиглэл урсгал, макро эдийн засгийн тогтворжилтод гүйцэтгэх үүрэг;
- Гадаадын зээллэг, тусламжийн макро эдийн засгийн нөлөө, үндэсний харьцуулсан судалгаа;
- Хөгжлийн албан ёсны тусламжийн удирдлага, мониторинг, мэдээллийн урсгал, санхүүгийн тайлагналын хэв загвар;

- Өрийн үйлчилгээ, тусламжийн орлогын макро эдийн засгийн санхүүгийн харьцаа ба индикаторуудын гаргалгаа, мэдээллийн загварчлал, хэрэглээний аспект;

Шинэлэг тал. Зах зээл төлөвшиж буй улс гүрэн, түүний дотор монголын нөхцөлд гадаадын зээл тусламж, өрийн үйлчилгээний удирдлагыг төгсжүүлэхэд чиглэсэн бүртгэл, мониторингийн мэдээлэл ба санхүүгийн тайлагналын шинэлэг хэв загвар, зарчмыг судалсанд оршино. Уг ажил нь

- Монгол улсын шингээж буй гадаадын зээл тусламжийн макро эдийн засгийн нөлөөллийг задлан шинжилсэн.
- Гадаад зээл, буцалтгүй тусламжийн удирдлага, мониторинг, зохицуулалтын хэв шинжүүд ба үндэсний санхүүгийн тайлагналыг загварчилсан.
- Өрийн үйлчилгээ, тусламжийн орлогын сангуудын макро эдийн засгийн санхүүгийн харьцааны индикатор ба жолоодлогын параметрууд гаргаж авах оролдлогууд хийгдсэн.

Практик ач холбогдол. Хөгжлийн албан ёсны тусламжийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, гадаад зээлийн багц, өрийн урсгалын дарамтыг илрүүлж, УСНББОУС-ын дагуу санхүүгийн хэмжилтүүд хийх ба тайлагнах үндэсний хэв загварыг хөгжүүлсэнд энэ судалгааны ажлын үнэ цэнэ оршиж байна. Диссертацийн судалгааны үр дүнгээр дараах дүгнэлт хийж байна:

Нэг. Гадаадын зээллэг, улсын өрийн дарамт - үндэсний аюулгүй байдал, урт хугацааны өсөлт, мөнгө, санхүү, орлого, хадгаламж, төсвийн алдагдал, төлбөрийн тэнцэлтэй нягт шүтэлцээтэй макро эдийн засгийн сэтгэлгээний нийлмэл ухагдахуун. Дж.Кейнсийн төрийн зохицуулалт, М.Фридман, Л.Мизес, Ф.Хаекийн мөнгөний нийлүүлэлтийн онол, Ж.Тобин, Р.Мандел, П. Самуэльсоны сангийн бодлого, эдийн засгийн өсөлтийн загвар орчин цагийн макро эдийн засгийн нарийн төвөгтэй үзэгдлүүдийг тайлж, зээл тусламж, өрийн удирдлагын үндсэн индикатор, жолоодлогын параметруудийг төгсжүүлэх гол шижмүүдийг нээж өгсөн.

Хоёр, Гадны зээл тусламжаар эдийн засгийг дэмжихэд засгийн газрын хэрэглээ, нийт өрийн дарамт өсч, эдийн засаг дахь нийт эрэлт нэмэгддэг ч санхүүжилтийн зардлын /үндсэн шилжүүлэг (элэгдэл), хүүгийн төлбөр/ хүлээлтээс макро эдийн засагт зайлшгүй дарамт үүсдэг. Эдгээр хүлээлт олон улсын капитал шилжилт, валютын ханшны өөрчлөлтийн байнгын нөлөөлөлд орж, макро эдийн засгийн үзэгдлүүдийн гинжин холбоос хийгээд өгөгдлийн сангууд дэхь жолоодлогын параметруудад нөлөөлж эхэлдэг.

Олон улсын капитал шилжилтээс жил бүр хождог, алддаг эсэхийг үзүүлдэг макро эдийн засгийн чухал үзүүлэлт - үндсэн шилжүүлгийн параметруудийг загварчилбал: $BT = dD - rD = D(d - r)$ болно. D - хуримтлагдсан өрийн дарамт, d - нийт өрийн өсөлтийн түвшин, r - зээллэгийн дундаж түвшин, dD - цэвэр капиталын дотогш урсгал, rD - жилийн зээллэгийн нийт төлбөр

Гурав. Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт хөгжлийн бүр эхнээс, бас шилжилтийн зурваст санхүүгийн хямрал, технологи, менежментийн

хоцрогдлыг арилгах үүднээс гадны зээл тусламжийг түлхүү авч, үндэсний макро эдийн засгийн тэнцвэрээ дэмжиж ирсэн, зөвхөн 1990 оноос хойш шингээсэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж 1,6 тэрбум ам.долларт хүрсэн. Дотоод орлого, хадгаламж, урсгал нөөцийн хомсдол, засгийн газрын хэрэглээ ба зардлын өсөлт, гадаад худалдааны төлбөрийн тэнцлийн доройтол нь гадаад зээлийн багц, улсын өрийн дарамт өсөх үндсэн шалтгаан болжээ.

Улсын өрийн дарамтын матриц, эрсдлийн судалгаа, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын индикаторуудын босго, параметруудийн үнэлгээнээс үзэхэд өрийн урсгалын олон параметрууд олон улсын хэмжээнд мөрддөг шалгуурын босго ба сэрэмжлэх твшингээс давсан байна. Энэ бүхнээс үндэсний эдийн засагт гадаад зээлийн багцыг шингээх чадвар хумигдаж, санхүүжилтийн зардлын хүлээлт, гадагш урсгалын өсөлтөөс дотоодын орлого, хадгаламж, экспортод дарамт үүсч, макро эдийн засгийн таагүй нөлөө өсөх хандлагатай болсон гэсэн дүгнэлт хийв.

Дорov. зээлийн багцын удирдлага, мониторинг, бодлогын хувьсал, өөрчлөлтийг төвлөрсөн төлөвлөгөөт, зах зээл гэсэн 2 зурвас, шилжилтийн үеийг дараах үечлэлд хуваах санал дэвшүүлж байна: а/ Хүнс, эрчим хүчний сэлбэг, байгалын гамшиг зэрэг онцгой үеийн тусламжийн үе (1990-1993), б/ Жижиг дунд үйлдвэр, хөгжлийн судалгаа, өөрчлөн байгуулалтын дунд хугацааны төслийн үе (1994-1998), в/ Бүтцийн өөрчлөлт (зам гүүр, дэд бүтэц), шинэтгэлийн төсөл, урт хугацааны хөтөлбөрүүдийг дэмжих үе (1998-2006).

Удирдлага, мониторинг, бодлогын хувьслын чухал шинж нь орчин үеийн төслийн менежмент загвар их эрчтэй нэвтэрч буй явдал юм. Төслийн менежмент нь алив өөрчлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлж, санхүүжилтийг зөвшөөрүүлэх үндсэн хэрэглүүр, шугаман үйлдлийн инженеринг, төслийн багийн /шинжээч, зөвлөх, гишүүд/ зохион байгуулалтад суурилдаг учир хөгжлийн талаарх мэдлэгийг тэлж, шинэ боломжийг нээж өгдөг байна.

Тав. Сан гэж зохих хууль, хэлцлээр тусгай зорилгод тогтсон хувь, хязгаарын дотор хөрөнгө тусгаарлах үйл явц. Бид түүнийг улсын секторын холбогдлын хүрээний цагираг дэхь өвөрмөц бүтэц, байгууламжаас үүдсэн мэдээллийн технологи ба мэргэжлийн сэтгэлгээний их төвөгтэй нийлмэл ухагдахуун гэж үзэж буй. Сангийн мэдээллийн багц бүхий өвөрмөц холбогдлын хүрээг үүсгэхийн тулд дараах үндсэн нөхцлүүд хэрэгтэй гэсэн судлаачид, сэтгэлгээний урсгалтай санал нийлж байна:

- Үйлдлийн зохион байгуулалт, тоглоомын дүрэм нь тодорхой байх,
- Санг эзэмшиж зарцуулах эрх бүхий санхүүгийн тусдаа нэгж байх,
- Зөвшөөрөгдсөн давхар бичилтийн бүртгэлийн системтэй байх.

Зургаа. Сангийн бүртгэлийн тогтолцоог томъёолохын тулд эхлээд 2 шатлалт засгийн газрын нэгж, анхан шатны төсвийн нэгж, улсын үйлдвэрийн газруудыг хамарсан улсын секторын холбогдлын хүрээг заавал хөндөж судлах хэрэгтэй болсон. Холбогдлын хүрээнд хамгийн бага зардлаар бүтээгдэхүүн нийлүүлж, эдийн засгийн нөөцийг өгөөжтэй ашиглахын тулд улсын секторын сангийн тайлагнал,

мониторингийн орчинг эрүүлжүүлэх ёстой гэж үзсэн. Энд төсвийн мониторинг, хараат бус хяналтын ач холбогдол их өсч буй. Холбогдлын цагирагт нэг цэгийн үйлчилгээ хүргэх үүднээс төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог бий болгосныг засаглал, шинэтгэлд хир нийцтэйг судлаж тогтоох ёстой.

Долоо. Засгийн газрын нөөц сангийн мэдээллийн технологи нь тусламжийн орлогын сан – гэрээний амлалт буюу инкамбранс, буцалтгүй тусламжийн /зарцуулалтын эрх хязгаарлагдмал/ орлогын бүртгэл, өрийн үйлчилгээний сан – хуримтлагдсан өглөг, шилжүүлэг, хүүгийн төлбөр, болзошгүй үүрэг хариуцлагын бүртгэлээс тус тус бүрдэнэ гэж үзлээ.

Найм. Өрийн үйлчилгээний мэдээлэл хувиргалт, сангийн тайланг УСНББОУТ-ын дагуу өөрчлөх шийдэл, горимын саналууд ба санал болгож буй туршилтын загварыг засгийн газрын IV-р ДЦС-д шингээсэн зээлийн жишээгээр харуулсан. Инкамбрансын бүртгэлд сайжруулалт хийх хувилбарыг Хятадын засгийн газраас буцалтгүй тусламжаар амласан 12000 тн шатахууны жишээгээр үзүүлэв. Зарцуулалтын эрх хязгаарлагдмал тусламжийн орлогын /авлага, найдваргүй авлага, зардал, алданги, торгууль, шилжүүлэг, үлдэгдэл, инкамбрансын нөөц/ өгөгдлүүдийн загварчлал, хаалтын бичилт, шалгах баланс, тайлангийн туршилтын загварууд диссертацид бий.

Ес. Монголын эдийн засагт гадаад зээлийн багцыг шингээх чадвар хумигдаж, үндэсний макро эдийн засгийн дарамт өсч буй энэ үед гадаад зээл тусламжийн удирдлага, мониторинг, бодлогын тогтолцоог үндсээр нь өөрчилж, орчин цагийн шугаман үйлдлийн инженеринг, төслийн менежментийн загварт нийцсэн сангийн бүртгэлийн мэдээллийн сүлжээг хөгжүүлэх нь туйлын чухал болов.

Юуны өмнө “Улсын өрийн үйлчилгээ, тусламжийн орлогын сангийн мэдээлэл хувиргалт, тайлагналын суурь зарчмууд” улсын секторын сангийн бүртгэлийн /стандарт/ бодлогын баримт бичиг манайд үгүйлэгдэж буй. Тэгээд ч гадаадын зээл тусламжийн урсгалийн хэмжил, тайлагналд хамгийн их холбогдох хөрөнгө, өр төлбөр /өрийн үйлчилгээ/, өмч, сан, зээл тусламжийн хөрөнгө оруулалт ба хэрэглээ, орлого, зардал, олз, гарз гэсэн дотоод уялдаа бүхий 10 бүрдэл хэсгийн ойлголт, шинж ба шалгуурыг аккруэл суурийн хэрэглээтэй холбож шинээр томъёолох оролдлогууд хийгдсэн болно.

Арав. Холбогдлын бүх цагираг, бүс, нэгжийг хамарч УСНББОУТ-д заасан аудитлагдсан тогтмол үнийн дүнгийн дан ба зэрэгцүүлсэн сангийн тайлан бэлтгэгдсэн тохиолдолд засгийн газрын авч шингээсэн гадаад зээллэг, төвлөрүүлсэн тусламжийн орлогын сангийн хүрээнд санхүүгийн харьцааг шинжилж, “Мүүдийн стандарт” олон улсын байгууллагын тогтоосон жишгээр жолоодлогын параметруудыг гаргаж авах боломж бүрдэж эхэлнэ.

Энд нэг хvн, хөрөнгийн нэрлэсэн vнэд өрийн үйлчилгээний эзлэх хувь, хvв төлөлт - бондын орлого, үйл ажиллагааний хөшүүрэг - бизнес сан, нэг хvнд ноогдох орон нутгийн орлого, үйл ажиллагааны зардал /нийт зардал эзэмшил нөөцийн орлого /нийт орлого, өрийн үйлчилгээ /нийт орлого, хуваарилагдаагүй сангийн тэнцэл /тусламжийн орлогын сан,

бодит зардал / тусламжийн орлогын сангийн төсөвлөсөн зардал гэсэн 10 торлийн санхүүгийн харьцааны индикатор буюу жолоодлогын параметруудад туршилтын хэмжилтүүд хийлээ.

Арван нэг. Гадаад зээлийн багцын шинжилгээнд төлбөрийн хугацааны үл дүйцэл, дахин санүүжилт, хөрвөх чадвар, төлбөрийн чадвар, зах зээл, үйлдлийн эрсдлүүдийг зайлшгүй суулгаж, үндэсний тооцооны системийн жолоодлогын суурь параметр буюу индикаторуудыг гаргаж авах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байна. Засгийн газрын өрийн үйлчилгээг бууруулахад олон улсын хэлцлээр хүчингүй болгох, урт хугацааны облигацид шилжүүлэх, санхүүгийн түрээс, факторингийн гүйлгээг хөгжүүлэх, экспортыг урамшуулж, импортын хориг саадыг нэмэх, стратегийн хөрөнгө оруулагчдыг тэнцвэржүүлж, нэг орон, бүлэг улсын хараат байдалд орохоос сэргийлэх нь чухал.